



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 638

Улаанбаатар хот

### Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд “Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагаа болон захирал Х.Баатартай холбоотой Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2019 оны Х/392 дугаар албан бичиг, иргэн С.Бүрнээгийн ирүүлсэн мэдээллийг нягталж, дүгнэлт гаргах Ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж, чиглэл болгосугай:

1.1 Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан компанийн бүтэц орон тоо, албан тушаалын жагсаалтыг удаа дараа өөрчилж Хувьцаа эзэмшигч болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд халдсан, батлагдсан бүтэц, орон тоогоор тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлээгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 35.1.4 дэх заалт зөрчсөн, Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн тухай хуулийн 5.1.4 дэх заалт болон “Хөдөө аж ахуйн биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох журам”-ыг зөрчин арилжаалагдаагүй бараа, түүхий эдэд тодорхойлолт олгосон, нөхөж арилжаанд оруулсан, тус журамд хууль зөрчсөн нэмэлт өөрчлөлт оруулсан зэрэг зөрчил гаргасан гүйцэтгэх захиралд Контрактын гэрээний 8.4-д заасан арга хэмжээг авах.

1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн хараат бус гишүүд хуульд заасан эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийг стратегийн удирдлагаар хангах, компанийн менежментэд Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс үр дүнтэй мониторинг хийх, компани болон хувьцаа эзэмшигчдийн өмнө ТУЗ-ийн гишүүдийн хүлээх хариуцлагыг дээшлүүлэх.

1.3. Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн тухай хуулийг мөрдлөг болгон ажиллах.

1.4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон компанийн ТУЗ-аас баталсан бүтэц, орон тоог дагаж мөрдөх, Хөдөлмөрийн тухай хуулийн 35.1.4-т заасны дагуу ажилтныг жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд ажлын байрыг нь хадгалж ажиллах чиглэлийг гүйцэтгэх удирдлагад өгөх.

1.5. Биржийн тодорхойлолтын үнэт цаасны бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дагуу анхан шатны баримтаар бүртгэж аваагүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 14.3.1 дэх заалтыг зөрчсөн, тодорхойлолт урьдчилан олгох, нөхөн арилжаанд оруулж, ажилдаа хариуцлагагүй хандсан зарим ажилтанд холбогдох хууль, журмын хүрээнд арга хэмжээ авах.

0001216

1.6. Компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах үүргийг гүйцэтгэх удирдлагад өгөх.

1.7. Компанийн хамт олны дотоод уур амьсгалыг эвдэн, үл ойлголцох байдал үүсгэсэн, үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулсан нөхцөлд гүйцэтгэх удирдлага болон компанийн эрх бүхий албан тушаалтнуудад шууд хариуцлага тооцох заалтыг гэрээнд тусган хэрэгжүүлэх.

1.8. Удирдамжийн биелэлт, гишүүдийн ирцийн мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөл хуралдсанаас ажлын 5 өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгох.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД